



159

ГОВЬСУМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 18 өдөр

Дугаар A/67

Шивээговь сум

Тамхи худалдан борлуулах тусгай  
зөвшөөрлийг олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2.1, 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.4, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2019 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 86 дугаар тогтоол “Сумын нутаг дэвсгэрт тамхины тусгай зөвшөөрөл олгох журам”-ын 2.1, 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт байрлах “Оюу Шивээ арвижих” ХХК-ийн супермаркетэд тамхи худалдан борлуулах тусгай зөвшөөрлийг 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрөөс 2025 оны 05 дүгээр сарын 16-ны өдрийг хүртэл 2 жилийн хугацаатай олгосугай.

2. Тусгай зөвшөөрлийн хураамж болох 250,000 (хоёр зуун тавин мянга) төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлж, хяналт тавьж ажиллахыг Хүнс, жижиг үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн (Д.Эрдэнэтулга)-д үүрэг болгосугай.

3. Тамхи худалдан борлуулах үйл ажиллагааг Тамхины хяналтын тухай хуулийн 5 дугаар зүйл, 6 дугаар зүйлийн 6.7.7, 6.7.8, 6.7.10, 6.7.12, 6.7.14 заалтыг, тусгай зөвшөөрөл олгох журмын 2.1 заалтын дагуу мөрдөж нийгмийн хариуцлагын гэрээ байгууллаж ажиллахыг Оюу Шивээ арвижих ХХК-ийн захирал (Б.Батчимэг)-т даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэнд байнгын хяналт тавьж ажиллахыг сумын Цагдаагийн хэсгийн дарга, цагдаагийн хошууч (Б.Шинэбаяр), Хүнс жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн (Д.Эрдэнэтулга) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

П.ГАНЧИМЭГ



42723 205